

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 04 дүгээр сарын 21

Улаанбаатар хот

Д/Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг, даалгавар-НЭГ:</b> Захиалагчийн хяналт тавьж байгаа, болон эрх шилжүүлсэн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, зураг төсөв, ажлын даалгаваргүй, байршил тодорхойгүй байгаа ажлуудаа яаралтай шийдвэрлэж, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг бүрэн хангах.				
1.	<p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/140 дугаар захирамжаар дүүрэгт эрх шилжиж ирсэн нийт 3 ажил байна. Үүнд:</p> <p>1. Чандмань овооны тохижилт /14 дүгээр хороо/ - ЧД-ийн Худалдан авах ажиллагааны алба дээр 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тендер зарлагдсан, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр нээнэ.</p> <p>2. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил – 1 /ЧД/ 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр тендер зарлагдсан, 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр нээнэ.</p> <p>Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах /ЧД/ – дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/772 дугаар албан бичгээр зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг хүргүүлсэн болно.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/140 дүгээр захирамжаар эрх шилжиж ирсэн нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 19, нийт 22 төсөл арга хэмжээ 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсанаас 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 22 төсөл, арга хэмжээ 100 хувь зарлагдсан бөгөөд тендерийг хүлээн авах, үнэлгээ хийх, шалгарсан оролцогчид мэдэгдэл дүгнэлтийг хүргүүлэх, амжилтгүй болсон тендерүүдийг дахин зарлах зэрэг ажиллагаанууд хийгдэж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
<b>Үүрэг, даалгавар ХОЁР:</b> Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад төсвийн тодотгол хийх бэлтгэл ажлыг сайтар хангаж, нийт байгууллагууд төсвийн сахилга батыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжүүлж ажиллах.				
2.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 4/641 тоот албан бичгээр Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 68 байгууллагад төсвийн тодотгол хийх бэлтгэл ажлыг хангах хүрээнд хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа ирүүлэх мөн Засгын Газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг баримтлан ажиллах талаар чиглэл хүргүүлэн ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30

<b>Үүрэг, даалгавар ГУРАВ:</b> 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлууд эрчимжүүлж ажиллах.				
3.	<p>- Дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр авч үзвэл Улсын төсөвт 14,7 тэрбум төгрөг төвлөрөхөөс 21,0 тэрбум төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 142.8 хувь, Нийслэлийн төсөвт 4,2 тэрбум төгрөг төвлөрөхөөс 7,7 төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 183.3 хувь, Орон нутгийн төсөвт 34,6 төгрөг төвлөрөхөөс 25,7 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 74.2 хувийн тус тус биелэлттэй гарсан байна.</p> <p>- “Хариуцлагатай бизнес эрхлэлт 30 жил” уриан дор нээлттэй өдөрлөгийг “Тэди худалдааны төв”-ийн гадна талбайд 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00-13:00 цагийн хооронд зохион байгуулхаар төлөвлөж байна. Тус өдөрлөгөөр QR код бүхий энгэрийн тэмдгээр татвар төлөгчдийг хангах, хариуцлагатай татвар төлөгчдийг шагнаж урамшуулах зэргээр татварын орлогыг нэмэгдүүлж, иргэдийн татварын боловсролыг дээшлүүлнэ.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Нийслэлийн хэмжээнд эвдэрч гэмтсэн зам талбай болон явган хүний замын тооцоо, судалгааг гаргаж, засварлах, сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулж танилцуулах.				
4.	Дүүргийн хэмжээнд эвдэрч гэмтсэн зам талбай болон явган хүний замын тооцоо, судалгааг гарган нийт 3597 м2 талбайд явган зам засвар, шинэчлэлтийн ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс засварын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн байдлаар нийт 1500 м2 явган зам шинэчлэн засварлаад байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
<b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, газрын зөрчил арилгах ажлын хүрээнд зөвшөөрөлгүй гарааш, хайс, хашааг буулгасан талбайг тохижуулах ажлаа эрчимжүүлэх.				
5.	Дүүргийн хэмжээнд зөвшөөрөлгүй барьсан гараашыг албадан буулгаж чөлөөлсөн газрыг тохижуулах ажлын хүрээнд нийт 3956 м2 талбайг тохижуулахаар тооцоо судалгааг гарган 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Хот тохижилтын ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Нийтийн эзэмшлийн газарт болон эзэмшиж ашиглаж байгаа газарт хууль дүрэм журам, зөрчиж, зөвшөөрөлгүй барьсан хашаа, хайсны зөрчлийг арилгах, газар чөлөөлөх ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих дэд ажлын хэсгийг байгуулж ажиллах.				
6.	- Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гараашийн газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөний дагуу 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 39 дүгээр цэцэрлэгийн урд тал, хойд талд зөвшөөрөлгүй баригдсан 34 гарааш, 2022 оны 04 дүгээр сарын 7-ны өдөр 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 62 дугаар байрны ард 20 байршлын 21 гарааш, 24 дүгээр байрны 5 гараашийг албадан буулгах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үлдсэн 8 байршлын 108 гараашийг газрын	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50

	<p>зөрчил арилгах календарьчилсан төлөвлөгөөний дагуу чөлөөлөхөөр бэлтгэн ажиллаж байна.</p> <p>- Нийслэлийн Засаг Даргын 2022 оны А/476 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайг хааж барьсан нийт 20 байршлын хашаа, хайсны 376 зөрчлийн судалгааг дэлгэрэнгүй гарган shp файл хэлбэрээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.</p>			
<p><b>Үүрэг, даалгавар ДОЛОО:</b> Бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд 74 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, цаашид бизнес эрхлэгчдээс ирүүлсэн гомдлыг шуурхай шалган шийдвэрлэж, хариуг цаг хугацаанд өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>				
7.	<p>Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд Онлайн бизнес төв цахим бүртгэлийн системд 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар худалдаа, хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн үйлчилгээ, авто үйлчилгээний чиглэлээр иргэн, аж ахуй нэгжээс нийт 231 хүсэлт хүлээн авсан байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Илгээсэн- 0</li> <li>- Шийдвэрлэсэн- 59</li> <li>- Судлагдаж байгаа- 9</li> <li>- Батлуулахаар шилжүүлсэн- 93</li> <li>- Буцаасан- 64</li> <li>- Цуцалсан-3</li> <li>- Татгалзсан-3 хариуг цаг хугацаанд өгч, хэрэгжилтийн явц 63 хувийн биелэлттэй байна.</li> </ul>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<p><b>Үүрэг, даалгавар НАЙМ:</b> Нийслэлийн хэмжээнд өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хурдан шуурхай шийдвэрлэж ажиллах.</p>				
8.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт <b>302</b> өргөдөл, гомдол ирснээс <b>248 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж</b>, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – <b>4</b>, шийдвэрлэх шатандаа <b>судлагдаж байгаа 50</b> өргөдөл, гомдол байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ иргэнд хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Иргэний талд шийдвэрлэсэн 150</li> <li>✓ Боломжгүй тухай хариу өгсөн 45</li> <li>✓ Бусад хариу өгсөн 53, Үүнээс:</li> <li>✓ Программ мессежээр 61</li> <li>✓ Программ мессеж утсаар 164</li> <li>✓ Программ мессеж албан бичгээр 27 байна.</li> </ul> <p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 2 цаг 35 минут байна.</p> <p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэх, зөрчлийг бууруулах зорилгоор Тамгын газрын харьяа хэлтэс албадын өргөдөл гомдлын нэгдсэн тоон мэдээ, зөрчлийн тайланг хэлтэс, албан хаагч бүрээр танилцуулан цаашид өргөдөл, гомдлын зөрчлийн тоог бууруулахаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

- Дүүргийн хэмжээнд Нийт 4250 албан бичигт хяналтын ажлыг хийж, 4205 бичгийг батлан, шийдвэрлэлт хангалтгүй 45 албан бичгийн шийдвэрлэлтийг цуцалж, 18 албан хаагчид зөрчил тооцон ажилласан.  
Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4.54 хоногтой байна.  
Дүүргийн хэмжээнд ирсэн албан бичгийн нэгдсэн тайланг Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороо, сургууль, цэцэрлэгийн удирдлагад "Зөрчил арилгаж, ажлын хариуцлагыг сайжруулах тухай" 2/897, 2/898, 2/899, 2/900, 2/901, 2/902 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

У.МАГНАЙ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДОЛГОРМАА